



## ЭРДЭС БАЙЛАГ, ЭРЧИМ ХУЧИИ САЙДЫН ТУШААД

2011 оны 6 сарын 8 едөр

Дугаар 137

Улаанбаатар хот

### Нөөц бүртгэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Эрдэс баялагийн Мэргэжлийн зөвлөлийн 2011 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн өргөтгөсөн хуралдааны 03 дугаар дүнэлтийг тус тус үндэспэн тушаах нь:

Нэг.Зүүнбаян, Цагаан-Элс (97БХГ)-ний ордод 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар газрын тосны геологийн нөөцийг тос агуулагч 18.3 км<sup>2</sup> талбайн ТЕ-14, ТЕ-1, ТЕ-27, ZB ба SWZB, EZB-1, EZB-4, WTE-1 гэсэн 7 блокт баталгаат зэрэглэлээр 26055.94 мян. тн буюу 186300.0 мян. баррелиар, 49.36 км<sup>2</sup> талбайн WTE-2, EZB хагарлын бусийн 3 блокт боломжит зэрэглэлээр 25580.42 мян. тн буюу 182900.0 мян. Баррелиар. Үнд:

1.1.Ашиглалтын нөөцийг баталгаат зэрэглэлээр 2079.12 мян. тн буюу 14865.70 мян. баррелиар,

1.2.Олборлосон тосыг 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар баталгаат нөөцөөс 831.23 мян. тн буюу 5943.29 мян. баррелиар, боломжит нөөцөөс 0.04 мян. тн буюу 0.28 мян. баррелиар,

1.3.Үлдэгдэл ашиглалтын нөөцийг баталгаат зэрэглэлээр 1247.89 мян. тн буюу 8922.41 мян. баррелиар тус тус Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэхийг Ашигт малтмалын газар /Д.Батхүяг/-т даалгасугай.

Хоёр.Зүүнбаян, Цагаан-Элс (97БХГ)-ний ордын газрын тосны нөөцийн хөдөлгөөнийг жил бүр зохиц журмын дагуу хийж, АМГ-ын Геологийн Мэдээллийн санд бүртгүүлж байхыг газрын тосны газар /Д.Амарсайхан/ болон “Доншен газрын тос/Монгол/” ХХК-д даалгасугай.


Гурав.“Доншен газрын тос /Монгол/” ХХК-д даалгах нь:

3.1.Нөөцийн үр дүнгийн тайланг зохих журмын дагуу дахин боловсруулж, Эрдэс баялаг, Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны энэхүү дүнэлт, Эрдэс баялаг, эрчим хүчиний сайдны тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын хугацаанд шинжээчид болон ЭБМЗ-ийн холбогдох гишүүдээр хянуулан, Газрын тосны газарт болон Ашигт малтмалын газрын Геологийн Мэдээллийн санд тус тус хүлээлгэн өгөх.

3.2.Дээрх 3.1 дэх заалтыг хугацаанд нь хэрэгжүүлэгчийг тохиолдолд зохих арга хэмжээг авахыг анхааруулж.

Дөрөв.Монгол Улсын газрын тосны нөөцийн ангилалын зааврыг боловсруулж, Эрдэс баягийн мэргэжлийн зөвлөл, Эрдэс баялаг, эрчим хүчиний сайдын зөвлөлөөр тус тус хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэхийг Газрын тосны газар /Д.Амарсайхан/, Эрдэс баялаг, эрчим хүчиний яамны Тулшиний бодлогын газар /А.Эрдэнэпүрэв/-т даалгасугай.

Тав.Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчиний яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Хурэлбаатар/-д урэг болгосугай.



Д.ЗОРИГТ